



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/151

Мандалговь

“Түшигмандал” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/44 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд хог зөөврийн автомашин нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Түшигмандал” ХХК-тай 87,500,000 (наян долоон сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд хог зөөврийн автомашин нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Түшигмандал” ХХК-ний захирал (С.Дарьбазар)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Сайнцагаан сумын Засаг дарга бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л. ДОРЖБАТ



486210022